

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БОДЛОГЫН ЗОХИЦУУЛАЛТ

Т. Нямдулам

Нийгмийн ухааны салбарын ахлах багш

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

nyamdulam12@must.edu.mn

А

***Хураангуй:** Улс орны хөгжлийг хурдасгагч зүйл нь бараа бүтээгдэхүүнээ дотооддоо үйлдвэрлэж хэрэгцээгээ хангаж илүүг нь экспортод гаргах явдал юм. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, бодлогоор хөгжүүлэх нь улс орнуудын эдийн засгийн нэн тэргүүний зорилго болсон хэвээр байна. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч хүн бүр өөрийн гэсэн бизнес эрхлэх, өмч хөрөнгөтэй болох, эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нийлүүлэх, хэрэглэгчдэд танил болох, ирээдүйдээ экспортын зарим бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, гадаад зах зээлд гаргах сонирхолтой байдаг бөгөөд тэр сонирхол нь өдөр тутам өсөн нэмэгдэж байдаг. Жижиг дунд үйлдвэрлэл гэдэг нь ажиллах хүчний болон үйлдвэрлэлийн цар хүрээгээр авсаархан, ихэвчлэн дотоод зах зээлд чиглэсэн, богино хугацаанд зардлаа нөхөж чадах, хөрөнгө бага шаарддаг, өндөр бүтээмжтэй, үйлдвэрлэлийн уян хатан технологитой, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг хэлдэг. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдэл орлогын тэгш бус хуваарилалтыг бууруулах, нийгмийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх болон хувийн секторын хөгжлийг хангахад онцгой хувь нэмрийг үзүүлдэг. Өгүүлэлд жижиг дунд үйлдвэрлэлийн талаарх төрийн бодлого, үйл ажиллагааны талаар авч үзэж санал дүгнэлт гаргасан болно.*

***Тулхуур үг:** жижиг бизнес, жижиг дунд үйлдвэр, санхүү хөрөнгө оруулалт*

УДИРТГАЛ

Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсны дараа эдийн засгийн хувьд гаднаас хараат бус, бие даасан бодлого хэрэгжүүлж үйл ажиллагаа явуулахад санхүүгийн хүндрэл бэрхшээл тулгарч байлаа. Эдийн засгаа либральчилж чөлөөт зах зээлийн эдийн засгийн зарчмаар хөгжүүлж хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг олноор байгуулах, тэдний үйл ажиллагааг дэмжиж ажиллах нь төрийн эдийн засгийн бодлогын салшгүй нэг хэсэг юм. 1990 оны дунд үеэс аж ахуй бизнесийн үй ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийг боловсруулж баталж хувийн хэвшлийн аж ахуйн байгууллагууд ч олноор байгуулагдах болсон. Тэр үеэс бизнес эрхлэгчдийн улс орны нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөө улам бүр өссөөр байна. Төрийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг хумигдаж улс орны хөгжил хувийн аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаатай шууд хамааралтай болж буй үед бизнес эрхлэгчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг төрийн бодлогоор дэмжиж,

урамшуулснаар тэдний улс орны эдийн засагт үзүүлэх үр нөлөө, үүрэг оролцоо дээшлэх юм. Ажилгүйдэл ядуурлыг бууруулж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгоход жижиг дунд үйлдвэрлэл чухал ач холбогдолтой салбар юм. Манай орон шиг зах зээлийн ихэнх хувийг гаднаас импортлодог, хөрөнгө санхүүгийн боломж бага, хүн ам цөөтэй, ажилгүйдэл ядуурал ихтэй орны хувьд үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд чухал үүрэг бүхий салбар юм. Сүүлийн жилүүдэд манай орны эдийн засаг, санхүүгийн байдал өмнөх онуудтай харьцуулахад харьцангуй сайжирч жижиг, дунд үйлдвэрийг төрөөс олон талт арга хэлбэрээр дэмжих бодлого баримталж байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

XVI-XVII зууны үед Францад жүжигчин, барилгачин, будагчин, засварчин, худалдаачин зэрэг хувиараа гэрээ хийж хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийг “entrepreneurship” гэж нэрлэдэг байжээ. XX зуунаас хойш жижиг бизнесийн нэр хүнд өсч, түүний нийгэм, эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүргийг нийтээр хүлээн зөвшөөрөх болсон. Энэ секторыг тодорхойлогч жижиг бизнес, жижиг дунд үйлдвэрлэл, жижиг үйлдвэр зэрэг нэр томъёо нь зарчмын хувьд адил боловч жижиг бизнес гэсэн ерөнхий шинжтэй ойлголтын хүрээнд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, зуучлалын үйл ажиллагаа хамаарч байна. Эдгээрээс Монгол оронд жижиг бизнес, жижиг дунд үйлдвэрлэл гэсэн ойлголтуудыг түлхүү хэрэглэгдэж байна. Жижиг дунд үйлдвэрлэл нь зах зээл, техник технологийн өөрчлөлт хөгжлийг хүлээн авах уян хатан мэдрэмжтэй, монополийн эсрэг байж өрсөлдөөнийг бий болгон, ажиллах хүчний зах зээлийн тогтвортой байдлыг ханган хүн амын орлогыг нэмэгдүүлэн үндэсний үйлдвэр, аж ахуйн системд тодорхой байр суурийг эзэлж байдаг эдийн засгийн бие даасан нэгж юм. Жижиг бизнесийн үйл ажиллагаа нь жижиг үйлдвэр, үйлчилгээ ба худалдааны байгууллагаар дамжин хэрэгждэг. Өөрөөр хэлбэл, жижиг бизнесийн оршин тогтнох орчин нь жижиг үйлдвэр юм. Жижиг, дунд бизнесийн нийгэмд гүйцэтгэж байгаа үүргийг тогтоох, тэдгээрийг дэмжих бодлогыг тодорхойлохын тулд жижиг дунд үйлдвэр гэдэгт ямар байгууллагыг хамааруулах талаар улс орон бүр өөр өөрсдийн эдийн засгийн хөгжил, нийгмийн тогтолцоо, соёл, зах зээлийн багтаамж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажиллагсдын тоо, нийт ба өөрийн хөрөнгө, орлогын хэмжээ зэргээс хамаарч харилцан адилгүй байдлаар тодорхойлдог. Олон улсын түвшинд Дэлхийн банкны гаргасан ангилалаар бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлж буй байдал, зах зээл дээрх орлогын хэмжээ, ажилтнуудын тоо зэргийг шалгуур болгон дараах байдлаар ангилж авч үздэг юм байна. Дэлхийн банкнаас олон улсын түвшинд жижиг бизнесийг дараах байдлаар тодорхойлсон байна.

№	Үйлдвэрлэлийн төрөл	Үндсэн хөрөнгө /мян. USA.S/	Ажиллагсдын тоо
1	Микро	100 ам доллароос бага орлоготой	1-19 хүртэл
2	Жижиг	100.000-3.000.000 ам доллар орлоготой	20-99 хүртэл
3	Дунд	3.000.000-15.000.000 ам долларын орлоготой	100-499 хүртэлх

Эх сурвалж: Дэлхийн банк Дэлхийн банкнаас санал болгож буй бизнесийн ангилал (ажиллагчдийн тоогоор)

Монгол улсын хувьд жижиг бизнес эрхлэгчийг дараах хүснэгтэнд үзүүлснээр ажиллагчдын тоо, борлуулалтын орлого, үйл ажиллагааны төрлийг гол болгон тодорхойлсон.

№	Үйлдвэрлэлийн төрөл	Ажилчдын тоо	Жилийн орлого
1	Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	10 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг	300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг
2	Жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг	300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг
3	Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	50-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг	1.0--2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг

Эх сурвалж: 2019 онд баталсан Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль

Төрөөс жижиг дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий ХХААХҮЯ-ын харьяа байгууллагууд болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг байгуулан ажиллаж байна. Засгийн газрын хүрээний энэ байгууллага жижиг дунд үйлдвэрийн хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд төрийн бодлого нь дараах үндсэн чиглэлийн хүрээнд тодорхойлогдож байна. Үүнд:

1. Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжиж эрх зүйн таатай орчин бүрдүүлэх
2. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд төрийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгох
3. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг татвар санхүүгийн бодлогоор дэмжих
4. Хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт явуулах, мэдээллээр хангах, зөвөлгөө өгөх

Дээрх бодлогын хүрээнд жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих талаар тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа бөгөөд дараах хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг батлан гаргасан байна. Үүнд:

- Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль,

- Татварын багцын тухайд нэмэлт өөрчлөлт оруулах тухай,
- Санхүүгийн түрээсийн тухай хууль,
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль дахь жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн тухай заалт, зохицуулалт,
- Үйлдвэрлэл технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл,
- Жижиг дунд үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмжийг 2009 оны 7-р сарын 16-аас 2012 оны 12-р сарын 31-ыг дуустал хугацаанд гааль болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль,
- Гааль болон НӨАТ-аас чөлөөлөх 683 төрлийн тоног төхөөрөмжийн жагсаалтыг баталсан засгийн газрын 2009 оны 316 дугаар тогтоол,
- Монгол улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр,
- Засгийн газрын 2009 оны 178 дугаар тогтоол "Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл".
- Засгийн газрын 2009 оны 173 дугаар тогтоол "хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хотолбөр"-г 2009-2017 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжсэн.

ЖДҮ-ийн эрх зүйн орчинг сайжруулан, хөгжүүлснээр өрсөлдөх чадвар бүхий жижиг дунд үйлдвэрүүд бий болж, ажлын байр нэмэгдэн, ажилгүйдэл, ядуурал буурч, дотоодын үйлдвэрлэл өсөх зэрэг чухал үр нөлөөтэй. Иймээс улс орнууд ЖДҮ эрхлэгчдэд хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд анхаарч, бодлогын арга хэмжээг авсаар байна.

Манай орны хувьд УИХ 2007 онд “Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль”-ийг баталсан нь ЖДҮ-ийн тодорхойлолт, ЖДҮ-ийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхой болгож, улмаар төрөөс жижиг, дунд үйлдвэрийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээ, хамрах хүрээг тодорхойлон үндэсний эдийн засгийн хөгжилд үзүүлэх хувь нэмэр, ач холбогдлыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Мөн ЖДҮ эрхлэгчдэд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээс буюу “Лизинг”-ээр авах боломжийг бий болгож “Санхүүгийн түрээс /Лизинг/-ийн тухай хууль”-ийг 2006 онд батлуулж хэрэгжүүлж байгаа нь барьцаа хөрөнгийн боломж тааруу бизнес эрхлэгчдэд худалдан авч байгаа тоног төхөөрөмжөө барьцаалан зээл авч үйл ажиллагаагаа явуулах боломж бүрдсэн. “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-д жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх санг оруулан хуульчилж өгснөөр ЖДҮ шинээр бий болох, өргөжин хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлсэн. Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлан, мөрдөж ажилласанаар уг хуульд парк байгуулах зорилгод ЖДҮ, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох гэж тусгаж өгсөн.

Жижиг, дунд үйлдвэрийг татвар санхүүгийн бодлогоор дэмжсэнээр ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор импортолж буй жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудыг 2009, 2014, 2017 онд баталж, хуулийн хүрээнд чөлөөлөгдөх тоног төхөөрөмжийн жагсаалтыг Засгийн газрын 2014 оны 191, 2017 оны 168 дугаар тогтоолоор баталсан.

Улс орны эдийн засаг эрчимтэй хөгжиж, зах зээлийн харилцаа гүнзгийрэх тусам Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг шинэчлэх, зохицуулалтыг өөрчлөх зайлшгүй шаардлага гарсан. Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.17-д “5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ” гэж, 2.15-д “Итгэлийн зээлийг олгож, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ” гэж, 2.48-д “... жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ” гэж, 2.50-д “Хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ” гэж тус тус заажээ.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 186-д “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг боловсруулах, ингэхдээ жижиг, дунд үйлдвэрийн ангиллыг өөрчлөх, өнөөгийн бодит байдалтай уялдуулан оновчтой тодорхойлох, жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих, төрөөс жижиг, дунд үйлдвэрт үзүүлэх дэмжлэгийг оновчтой болгох эрх зүйн орчинг бүрдүүлэхээр заасан байна.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төрийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санхүү хөрөнгө оруулалтын бодлогыг сайжруулах гэсэн хүрээнд судалж үзэхэд хууль тогтоомжид тодорхой заалтууд тусгагдсан хэдий ч хэрэгжүүлэх шатандаа алдаа гардаг, хуулийг буруу хэрэгжүүлдэг улмаар ЖДҮ-г дэмжсэн дэмжлэг жинхэнэ эзэндээ хүрэхгүй байх тохиолдолууд байна.

Эхний бүлэгт жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангилал, дэмжлэгийг оновчтой болгох, дэмжигч байгууллагын эрх үүргийн талаарх эрх зүйн орчинг боловсронгуй болгох
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээл, төсөлд хамрагдсан аж ахуйн нэгж, иргэдийн хариуцлагыг сайжруулах, зээлийн эргэн төлөлтийн эрсдэлийг бууруулах, хугацаа хэтэрсэн өглөг, авлага үүсгэхгүй байх талаар холбогдох журам, гэрээний нөхцөлийг сайжруулах
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор батлан даалт, даатгалын эрх зүйн орчинг сайжруулах
- Лизингийн үйлчилгээ, батлан даалтын эрх зүйн орчинг шинэчлэн хөнгөлөлттэй зээл авах жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн тоог нэмэгдүүлэх
- Инноваци, технологи нэвтрүүлэх, мэдлэг хуваалцах чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ажиллах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох
- Жижиг дунд үйлдвэрлэлийн менежментийн үйл ажиллагааг дэмжих, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, гарааны бизнесийг хөгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх

Жижиг дунд үйлдвэрийн санхүү хөрөнгө оруулалтын боловсронгуй болгох чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, зээлийн шинэ бүтээгдэхүүнийг бий болгон зээлийн хүү, хугацаа, олгох үйл ажиллагааг оновчтой болгох
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх замаар эрэлтэд нийцсэн зээлийн бүтээгдэхүүн бий болгон хөгжүүлэх
- Олон улсын сайн туршлагад нийцсэн, санхүүгийн байгууллагуудын шаардлагыг хангасан иргэд болон аж ахуйн нэгжийн мэдээллийг агуулсан зээлийн мэдээллийн сан байгуулахад дэмжлэг үзүүлэх
- Санхүүжилтийн бусад эх үүсвэр, лизинг болон факторингийн талаарх ойлголт, хэрэглээг нэмэгдүүлэх, экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд зориулсан батлан даалт, даатгалыг нэвтрүүлэх
- Хамтарсан болон хоршсон хөрөнгө оруулалтын ач холбогдлыг сурталчлах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад танилцуулан, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх

Дээрх бодлого чиглэлийн хүрээнд үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Зарим нэг үйл ажиллагааны хэрэгжилтээс дурьдвал:

- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан бий болгож сангаас шууд, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид банкаар дамжуулан зээл олгодог болсон.
- Дунд үйлдвэр эрхлэгч бүтээгдэхүүнээ экспортод гаргасан тохиолдолд банкнаас авсан зээлийн жилийн хүүгийнх нь 5.0 хүртэл хувийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгож болохоор, Сангийн тухайн жилийн санхүүжилтийн 80-аас доошгүй хувийг үйлдвэрлэлийг дэмжих зориулалтаар олгохоор тусгасан
- Төрийн байгууллага, эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын улмаас Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээл зорилтот бүлэгтээ очдоггүй байсныг өөрчлөх зорилгоор уг сангийн үйл ажиллагааны болон зээл олгох, сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батлахаар өөрчилж, хууль зөрчсөн хүн, хуулийн этгээд, төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуультай уялдуулсан зохицуулалтууд гаргасан.
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг цахимаар бүртгэх, цахим мэдээллийн сан бий болгох эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.
- Жил бүрийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын 10 хувиас доошгүй хэмжээний мөнгөн хөрөнгийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд төвлөрүүлж, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зориулалтаар зарцуулахаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгасан. 2030 он хүртэл хугацаанд ийнхүү улсын төсвөөс хөрөнгө хуваарилах бөгөөд түүнээс цааш Сан бие даан ажиллах боломжийг бүрдүүлэх юм.

Олон улсад жижиг дунд үйлдвэрийг сайн хөгжүүлсэн туршлагууд олон байна. Тухайлбал: БНСУ-ын жишээг дурьдаж болно.

БНСУ-ын эдийн засаг маш богино хугацаанд хөгжингүй орны түвшинд хүрсэн нь олон улсын судлаач, эдийн засагч нарын анхаарлыг татсан бөгөөд энэхүү эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн талаар нэлээд судалгаа хийгджээ. Дэлхийн II дайны дараах үеэс эхэлсэн эдийн засгийн өсөлтөд “Чаэбул” буюу тухайн орны том компаниуд гол үүрэг гүйцэтгэсэн гэж судлаачид үзэж байгаа боловч ЖДҮ-үүд багагүй хувь нэмэр үзүүлжээ. Өнөөгийн байдлаар БНСУ-ын нийт аж ахуйн нэгжүүдийн 99.9 хувь нь ЖДҮ эрхлэгчид бөгөөд тэдгээрт эдийн засгийн идэвхтэй хүн амын 90 хувь нь хүн ажилладаг. ЖДҮ-үүд ДНБ-ий 50 гаруй хувь, нийт экспортын 35 гаруй хувийг бүрдүүлж байна. ЖДҮ-ийн дийлэнх нь бичил бизнес эрхлэгчид бөгөөд тэдгээр нь ихэвчлэн бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг байна.

Монгол Улсад одоогийн байдлаар бүртгэлтэй 78585 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас 60330 нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгч байна. Улсын хэмжээнд 1 226 942 хүн хөдөлмөр эрхэлж байгаагаас энэ салбарт 78,3 хувь нь буюу 906 495 хүн ажиллаж байгаа юм.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлд Жижиг, дунд үйлдвэрийн тухай, Үйлдвэр, технологийн эрх зүйн байдлын тухай, Татварын тухай, Хоршооны тухай, Санхүүгийн түрээс, лизингийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай зэрэг хууль, Аж үйлдвэрийг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого зэрэг бодлогын баримт бичиг, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр, Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр, Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг эрх зүйн актууд үйлчилж байна. Энэ салбарт төрөөс санхүүгийн дэмжлэг болгон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Зээлийн батлан даалтын сан, Сум хөгжүүлэх сангаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгож байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын эдийн засаг зах зээлийн шилжилтийн үеэс өсөлт бойжилтын үедээ явж байна. Үүнтэй уялдан жижиг дунд үйлдвэрлэл, бизнес ч өсөн нэмэгдэж одоогийн байдлаар улсын төсвийн орлогын 80 орчим хувийг бүрдүүлж, нийт аж ахуйн нэгж байгууллагын байгууллагын 96 орчим хувийг эзэлж байна. Эдийн засгийг өсгөх гол хөшүүрэг нь жижиг дунд бизнесийг дэмжих явдал бөгөөд жижиг дунд үйлдвэрлэлийг өсгөх үр ашигтай ажиллах нөхцөл бололцоог бүрэлдүүлж нийгэм эдийн засагт үр ашигтай санал, үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх шаардлага тавигддаг. Манай эдийн засгийн бүтцэд жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес давамгайлж байгаа өнөөгийн нөхцөлд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлс, тулгарч буй асуудлуудыг илрүүлэн шийдвэрлэх явдал улс орны эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, түүний үйл ажиллагааг өргөжүүлэх нь бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, ажлын байрыг шинээр бий болгох, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээнд шударга өрсөлдөөнийг бий болгоход чухал ач холбогдолтой. Төрөөс жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, үйлдвэрлэл эрхлэгч нарт бүх талаар дэмжлэг үзүүлэх бодлогын баримт бичиг боловсруулж баталсан хэдий ч хэрэгжүүлэх шатандаа алдаа завхрал байсаар байна. Тиймээс жижигдунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгө эзэндээ очиж буйд төрийн

байгууллага, бизнес эрхэлэгчид, иргэний нийгмийн байгууллагууд тала талаасаа хяналт тавьж хамтран ажиллах шаардлагатай байна.

НОМЗҮЙ

[1] Жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хууль. 2019

[2] Засгийн газрын тусгай сангийн хууль. 2019

[3] Санхүүгийн түрээсийн тухай хууль

[4] Жижиг дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр. 2019

[5] ХХААХҮЯ, “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн тайлан”

[6] Монгол банкны “Түүвэр судалгааны тайлан” 2016, 2017

[7] Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн гарын авлага. 2020